

## “ЯПОН УЛСТАЙ БАЙГУУЛСАН ЭЗТХ-ИЙН АЧ ХОЛБОГДОЛ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ”

**Н.Батнасан\***

**Хураангуй:** Энэхүү өгүүлэлд өнгөрсөн жил байгуулсан Монгол-Японы ЭЗТХ-ийн ач холбогдолыг тодорхойлж, ерөнхий тэнцвэрийн динамик загварт тулгуурлан хэлэлцээрийн эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тооцож харуулахыг зорилоо.

**Түлхүүр үг:** Монгол-Японы харилцаа, ЭЗТХ, ЧХХ

### **Чөлөөт худалдааны хэлэлцээр ба Монгол улс**

Өнөөг хүртэл Монгол улс өөрийн худалдааны түнш 30 гаруй улс оронтой хоёр талын худалдаа-эдийн засгийн хамтын ажиллагааны гэрээг байгуулсан боловч олон жилийн туршид ямар нэгэн улстай Чөлөөт худалдааны хэлэлцээр (ЧХХ) байгуулаагүй ДХБ-ын гишүүн цорын ганц орон байсаар ирсэн билээ.

Япон улстай байгуулсан ЭЗТХ-ээс өмнө Монгол улс эдийн засгийн тодорхой бүлэглэл болон ЧХХ-т нэгдэн ороогүй талаар олон шалтгааныг энд дурдаж болох ч хамгийн гол нь манайх мэтийн жижиг буурай орон хэлэлцээрт нэгдэн орсон нөхцөлд тухайн хэлэлцээрийн хүрээнд өөрийн ашиг сонирхлыг хэрхэн хамгаалах, оролцогч талуудтайгаа үр ашигтай хэлцэл хийж чадах эсэх гэх мэт олон эргэлзээтэй асуудлууд байсан нь голлох шалтгаанд тооцогдох болов уу.

Монгол улс эдийн засаг шилжилтийн эхэн үеийн хямралыг амжилттай даван туулж, улмаар эдийн засаг тогтвортой өсөх хандлагатай болж, улс орны гадаад худалдааны хэмжээ урьд өмнөхтэй зүйрлэмгүй ихээр өссөн өнөө үед худалдаа — эдийн засгийн тодорхой бүлэглэлд нэгдэх, ЧХХ байгуулахын ач холбогдол улам бүр өсөн нэмэгдсээр байна.

Ямарваа ЧХХ-т нэгдсэн орнууд өөр хоорондын худалдаан дахь гаалийн тарифыг “тэглэж”, тарифын бус хориг саадуудыг байж болох хамгийн бага хэмжээнд хүртэл бууруулах үүрэг амлалтыг харилцан хүлээдэг. ЧХХ түүнд нэгдэн орсон улс орнуудын экспортлогчдод шинэ зах зээлд хөнгөлөлттэй

\* МУИС-ийн, Бизнесийн сургуулийн профессор, (E-mail) batnasan\_n@hotmail.com

нөхцлөөр нэвтрэн орох давуу боломжуудыг бий болгодог. Нөгөө талаас дотоодын зах зээл ЧХХ-т нэгдсэн түнш улс орнуудын хувьд илүү нээлттэй болох тул үндэсний үйлдвэрлэгчид импортын өрсөлдөөнөөс хамгаалах хамгаалалтгүй болдог. Тиймээс өрсөлдөх чадвар муутай салбаруудын үйлдвэрлэл богино болон дунд хугацаанд уналтад орж, ажилгүйдэл нэмэгдэж болох талтай.

ЧХХ байгуулснаар түүнд нэгдэн орсон улс орнуудад өрсөлдөөний түвшин нэмэгдэж, зах зээл дэх үнэ буурах хандлага ажиглагддаг юм. Үнийн бууралт нь хүн амын амьжиргааны түвшин дээшлэхэд, өрсөлдөөний өсөлт нь урт хугацаанд үйлдвэрлэлийн харьцангуй давуу талдаа тулгуурласан эдийн засгийн зохистой бүтэц бий болоход тус тус эерэг нөлөөлөл үзүүлдэг.

Практикаас үзэхэд, дэлхийн улс орнууд ЧХХ байгуулах замаар хөрөнгө оруулалтын илүү тааламжтай орчин нөхцлийг бүрдүүлэхийг эрмэлздэг. Хөрөнгө оруулалтын орчин нөхцлөө сайжруулах замаар гадаадын шууд хөрөнгө оруулалтыг ихээр татаж, үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмж, түүхий эдийн нийлүүлэлтийг нэмэгдүүлж, шинэ ажлын байруудыг бий болгож, дэвшилтэт технологи, үйлдвэрлэлийг эрхлэн хөтлөх шинэ арга барилыг нэвтрүүлэхийг зорьдог. Улс төрийн талаас нь авч үзвэл, бага буурай орнууд ЧХХ-т нэгдэн орох замаар ДХБ-ын хүрээнд хэлэлцээр явуулах чадавхиа дээшлүүлж, өөрийн ашиг сонирхлоо хамгаалахыг эрмэлздэг байна.

ЧХХ-т нэгдсэнээр эдийн засгийн хувьд хожих, алдах магадлалын аль аль нь бий тул түүнд нэгдэн орохоосоо өмнө нэгд, хэлэлцээрт нэгдэх нь улс орны хөгжлийн стратегитэй нийцэх эсэхийг, хоёрт, ямар улс оронтой хэлэлцээр байгуулбал эдийн засгийн хувьд илүү үр ашигтай болохыг, гуравт, тодорхой улс оронтой хэлэлцээр байгуулснаар урт болон дунд, богино хугацаанд бий болох давуу болон сул талууд, дөрөвт, хэлэлцээр улс орны эдийн засаг, түүний өсөлтөд хэрхэн нөлөөлөхийг, тавд, хэлэлцээр эдийн засгийн салбарууд, бүс нутгууд, хүн амын орлогын бүлгүүдэд хэрхэн нөлөөлөх зэргийг урьдчилан тооцсон байх шаардлагатай.

Монгол улс бол далайд шууд гарах гарцгүй, гадаад тээвэрлэлтийн зардлын түвшин хамгийн өндөртэй орнуудын нэг юм. Тээврийн өндөр өртөг зардал Монголын гаралтай барааны өрсөлдөх чадварыг бууруулж, импортлож буй барааны үнийг өндөрсгөж байдаг.

Манай орны хувьд тээврийн өртөг зардлыг бууруулах 3 үндсэн арга бий. Эдгээр нь нэгдүгээрт, тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх, хоёрдугаарт,

газарзүйн байршлын хувьд ойрхон улс орнуудтай худалдаа, гуравт, түүхий эдийн боловсруулалтын түвшинг нэмэгдүүлэх замаар овор хэмжээ багатай, үнэ ихтэй эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зэрэг болно.

Монгол улсын хувьд нэгд, гадаад худалдаанд зонхилох байр суурийг эзэлсээр ирсэн БНХАУ, ОХУ-аас эдийн засгийн хувьд хараат байдлаа бууруулах, хоёрт, техник, технологийн хөгжлөөрөө Орос, Хятадаас давуутай улс орнуудтай түншлэж, эдгээр орны зах зээлд амжилттай өрсөлдөж чадах харьцангуй давуу тал бүхий бүтээгдэхүүнийг бий болгохын тулд техник, технологи хөгжсөн, газарзүйн байршлын хувьд ойр дөт, өндөр хөгжилтэй, Монголтой эдийн засгийн болон улс төрийн хувьд нийтлэг ашиг сонирхол бүхий томоохон улс оронтой хамтран ажиллах шаардлагатай байгаа юм.

Монгол улсын хувьд худалдааны түнш орнууд дотроосоо хамгийн түрүүнд Япон улстай ЧХХ-ийн нэг хэлбэр болох Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр (ЭЗТХ) байгуулсан нь санамсаргүй хэрэг биш ээ. Монгол улс Япон улстай ЭЗТХ байгуулсан нь дор дурдсан үндэслэл, шалтгаануудтай. Үүнд:

- Япон улс нь өндөр хөгжилтэй орнуудын дотроос газарзүйн байршлын хувьд хамгийн ойр дөт байршилтай төдийгүй дэлхийн зах зээл дээр зэс, кокс зэрэг бүтээгдэхүүнийг худалдан авагч гол орнуудын нэг юм. Тиймээс Япон улс нь манай стратегийн бүтээгдэхүүнүүдийн гол худалдан авагч болох магадлал өндөр.
- Японы хөрөнгө оруулалтыг татах замаар стратегийн ач холбогдол бүхий салбарууддаа энэ улсын техник технологийг үйлдвэрлэлд өргөнөөр нэвтрүүлэх нь манай улсын экспортын өрсөлдөх чадварыг дээшлүүлж, тээврийн өртөг зардлыг бууруулахад төдийгүй хөрш орнуудаас хараат байдлаа бууруулахад чухал ач холбогдолтой.
- Ардчилсан нийгэм, зах зээлийн тогтолцоо, хуулийг дээдлэх ёс, хүний эрх гэх мэт адилхан үнэт зүйлс бүхий Япон улстай нөхөрсөг харилцааг хөгжүүлж, Ази Номхон далайн бүс нутагт болон олон улсын тавцанд харилцан бие биеэ дэмжих нь дипломат бодлогын хувьд чухал ач холбогдолтой юм.

Хэлэлцээр амжилттай байгуулагдаж, хэрэгжих шатандаа орсон бөгөөд энэхүү судалгааны ажлаараа Монгол-Японы хооронд байгуулсан ЭЗТХ-ийн ач холбогдол, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тооцож харуулахыг зорив.

Олон улсын практикаас үзэхэд ЧХХ-ийн эдийн засагт үзүүлэх нөлөөллийг дараахь үзүүлэлтүүдээр дамжуулан судалдаг байна. Үүнд:

- Эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөөлөл
- Үйлдвэрлэл, хэрэглээнд үзүүлэх нөлөөлөл
- Төсвийн орлого, зарлагад үзүүлэх нөлөөлөл
- Худалдааны тэнцэлд үзүүлэх нөлөөлөл
- Орлогын хуваарилалтад үзүүлэх нөлөөлөл

ЧХХ-т нэгдэн орсон нөхцөлд гарч болох эерэг болон сөрөг нөлөөллийг нэгэн бүхэл системийн хүрээнд хамтатган судлах, үнэлэх боломж зөвхөн Ерөнхий тэнцвэрийн загвар (ЕТЗ)-т тулгуурласан судалгааг ашигласан нөхцөлд бүрддэг.

Энэхүү судалгааны ажилд ЕТЗ-ыг ашиглан ЭЗТХ-ийн Монгол улсын эдийн засагт үзүүлэх эерэг ба сөрөг нөлөөллийг үнэлэх, дотоодын үйлдвэрлэл, хэрэглээ, ДНБ, экспорт, импорт, төсвийн орлогод үзүүлэх нөлөөллийг тооцох, хэлэлцээрээр нээгдэж буй эдийн засгийн хамтын ажиллагааны шинэ боломжуудыг тодруулах үндсэн зорилтуудыг тавьсан болно.

### **Монгол-Японы эдийн засгийн хамтын ажиллагааны товч түүх**

Түүхэн сурвалжуудаас үзэхэд Монгол-Японы харилцаа олон зууны тэртээгээс эхтэй боловч хоёр орны хооронд 1972 онд дипломат харилцаа тогтоосон. 1977 онд Япон улс дэлхийн хоёрдугаар дайны үед Монгол улсад учруулсан хохирлынхоо нөхөн төлбөрт “Говь” ноолуурын үйлдвэрийг барьж байгуулах гэрээг хийсэн бөгөөд 1990-ээд оныг хүртэл хоёр орны хоорондын эдийн засгийн харилцаа уг үйлдвэртэй холбоотой техник, технологийн харилцаанаас төдийлөн хэтэрч байгаагүй билээ.

Хоёр орны хоорондын найрсаг хамтын ажиллагаа зөвхөн 1990-ээд оны эхэн үеэс эхтэй бөгөөд Халх голын байлдаан, Дэлхийн хоёрдугаар дайны нөлөөгөөр хүйтэрсэн хоёр улс, хоёр ард түмний хоорондын харилцааны “мөс” чухамхүү энэ үеэс эхлэн хайлж эхэлсэн гэж үзэж болно.

Хоёр улсын шинэ харилцаа эхэн үедээ Япон улсын зүгээс Монголд үзүүлэх буцалтгүй зээл, тусламжийн хөтөлбөрүүдээр дамжин хэрэгжиж эхэлсэн бөгөөд 1990-ээд оны эхээр зах зээлийн эдийн засаг, ардчилсан нийгмийг хөгжлийн чиг баримжаа болгон сонгон авч, улс төр, эдийн засгийн ардчилсан өөрчлөлтүүдийг түргэн хурдацтай хэрэгжүүлж эхэлсэн Монгол улсын хүчин чармайлыг Япон улс үнэлэн үзэж, “Монголд зээл, тусламж үзүүлэх замаар тус улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжих нь мөн нэгэн адил хүчин зүтгэл гаргаж буй

бусад хөгжиж буй орны ардчилсан хөгжлийг дэмжиж байгаа хэрэг болно”<sup>2</sup> гэж үзэж байсан нь баримт бичгүүдэд тэмдэглэгдэн үлджээ.

Эхэн үедээ Япон улсаас Монголд үзүүлж байсан тусламж дэмжлэг нь шилжилтийн үеийн хүндрэл бэрхшээлүүдийг зөөллөхөд чиглэж байсан ба энэ талаар Японы Засгийн газар “шилжилтийн үеийн эмх замбараагүй байдлаас үүдэн яаралтай шаардагдах болсон хэрэгцээг хангахад чиглэсэн тусламж үзүүлж байлаа”<sup>3</sup> хэмээн мэдэгдсэн нь бий. Хүнд бэрх жилүүдэд Япон улсаас үзүүлсэн хүмүүнлэгийн тусламж нь Монголчуудын нийтийн талархлыг хүлээх болсон юм.

Ерээд оны дунд үеэс Япон улсаас Монголд үзүүлсэн зээл тусламж нь тодорхой зорилго чиглэлтэй болж эхэлсэн байна. Япон улсаас Монголд үзүүлсэн хандив тусламж нь дор дурдсан гол үндсэн чиглэлүүдэд төвлөрч байжээ. Үүнд:

- Аж үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд шаардлагатай түгээлтийн систем, эрчим хүч, харилцаа холбооны дэд бүтцийг сайжруулахад,
- Зах зээлийн эдийн засагт шилжих үйл явцад дэмжлэг үзүүлэх, түүний дотор бүтцийн өөрчлөлт, хүний нөөцийг хөгжүүлэх зэргээр оюуны болон хүний нөөцийн чадавхийг дэмжихэд,
- ХАА-н салбарын хөгжлийг дэмжих, малын тэжээлийн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд,
- Боловсрол, эрүүл мэнд, хотын дэд бүтэц, хөдөөгийн усан хангамжийг сайжруулах зэргээр хот, хөдөөгийн нийгмийн үйлчилгээг дэмжихэд,
- Гамшгаас сэргийлэх, гамшгийн эрсдлээс сэргийлэх яаралтай тусламжийн нөөцийг бүрдүүлэхэд туслах зэргээр байгалийн нөөц баялагийн зүй зохистой менежментийг бий болгоход;

2006 онд айлчилсан Япон улсын Ерөнхий сайд Жүничиро Коизуми Монгол-Японы хамтын ажиллагааны талаар “хуулийг дээдлэх ёс, хүний эрх гэх мэт адилхан үнэт зүйлстэй харилцаагаа хөгжүүлэх нь чухал ач холбогдолтой” гэж дүгнэж байв.<sup>4</sup>

2013 оны 3-р сард Япон улсын Ерөнхий сайд Шинзо Абэгийн айлчлалын үеэр Монгол-Япон улс нь байгалийн нөөц баялаг, худалдаа болон байгаль орчны асуудлаар хамтран ажиллахаар тохиролцсон. Хоёр орны байгалийн

<sup>2</sup> JICA “Japan’s country assistance program for Mongolia” November 2004

<sup>3</sup> JICA “Japan’s country assistance program for Mongolia” November 2004

<sup>4</sup> Japan times, 4 April 2013

нөөцийн салбар дахь харилцаа нь “win-win” зарчимд тулгуурлах ёстойг ноён Шинзо Абэ онцолсон.<sup>5</sup>

Хэдийгээр эдийн засгийн хувьд жижигхэн, 3 сая гаруйхан хүн амтай боловч газар нутгийн хэмжээгээр Японоос 4 дахин том Монгол улс нүүрс, зэс, алт, уран, ховор металл, газрын ховор элементүүд гэх мэт байгалийн арвин баялаг нөөц баялагаараа Япон улсын анхаарлыг зүй ёсоор татаж байдаг. Түүн дээр Орос, Хятад зэрэг дэлхийн томоохон улс гүрнүүдтэй хиллэсэн газарзүйн байршил, Хойд Солонгостой тогтоосон найрсаг харилцаа, хамтын ажиллагаа зэрэг нь Монгол улс геополитикийн хувьд Япон улсын анхаарлыг татах болсон өөр шалтгаанууд нь юм.

Монгол улс олон тулгуурт гадаад харилцааны бодлогын хүрээнд Япон улстай гуравдагч түншийн хэмжээнд харилцаагаа өргөжүүлэхийг эрмэлзэж ирсэн. Монгол улс Япон улстай худалдаа эдийн засгийн харилцаагаа өргөжүүлэх, Японы техник технологи, хөрөнгө оруулалтад тулгуурлан өрсөлдөх чадвараа дээшлүүлэх, худалдааны тэнцлээ сайжруулах, Хятад, Оросоос хараат байдлаа бууруулахыг эрмэлзэж байгаа бол Япон улс газарзүйн байршлын хувьд ойр дөт Монгол орны байгалийн нөөц баялгийг авч ашиглахыг илүүтэй чухалчилж байгаа юм.

Япон улс нь Монголын худалдааны дөрөв дэх томоохон түнш орон бөгөөд шилжилтийн эхэн үеэс буюу сүүлийн 20 гаруй жилийн туршид энэ орон Монгол улсын хувьд хамгийн том хандивлагч орон байсаар ирсэн билээ.

Монгол улс 2015 оны байдлаар 4669.3 сая ам долларын бараа бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд экспортлосон бөгөөд үүний 0.43%-тай тэнцэх 20.30 сая ам.долларын барааг Япон улсад экспортлосон.<sup>6</sup> Мөн онд Япон улсаас 274.6 сая ам.долларын барааг импортлосон нь манай улсын нийт импортын 7.23%-тай тэнцэж байна<sup>7</sup>. Харин манайхаас экспортлосон бараа Японы нийт импортод 0.0087%-ийг, Япон улсаас импортлосон бараа тус улсын нийт экспортын 0.04%-ийг тус тус эзлэж байна.<sup>8</sup> Японоос оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ жил бүр харилцан адилгүй түвшинд байгаа бөгөөд 2015 онд 38.2 сая ам.долларын хөрөнгө оруулсан нь манай улсад мөн онд оруулсан ГШХО-ын 7.0 орчим хувьтай тэнцэж байгаа юм.<sup>9</sup> Япон улс нь

<sup>5</sup> Japan times, 4 April 2013

<sup>6</sup> ГТЕГ “Гадаад худалдааны барааны гаалийн статистик мэдээлэл 2015” УБ 2016

<sup>7</sup> ГТЕГ “Гадаад худалдааны барааны гаалийн статистик мэдээлэл 2015” УБ 2016

<sup>8</sup> WTO/UNCTAD International trade center “Trade statistics 2015”

<sup>9</sup> Монгол банк “Монгол улсын гадаад секторын тойм” УБ 2015 ху 3

шилжилтийн жилүүдэд Монголд үзүүлсэн хандив тусламжийн хэмжээгээрээ тэргүүлэх байрыг эзэлдэг бөгөөд одоо ч энэ байр сууриа хадгалсан хэвээр байна. Япон улсаас 1990 - 2013 онуудад Монголд 1.6 тэрбум ам.долларын хөгжлийн албан ёсны тусламж үзүүлжээ.<sup>10</sup>

Япон улсын Ерөнхий сайд ноён Шинзо Абэгийн айлчлалын үеэр Монгол — Япон улсуудын хооронд эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулах зорилтыг дэвшүүлсэн нь эдүгээ амжилттай хэрэгжлээ. Хоёр орон энэхүү хэлэлцээр хоёр орны хоорондын харилцааг шинэ шатанд гаргана байх хэмээн найдаж, хэлэлцээрт ихээхэн ач холбогдол өгч байгаа юм.

### **ЭЗТХ-ийн үйлдвэрлэл, хэрэглээ, ДНБ, экспорт, импорт, төсвийн орлогод үзүүлэх нөлөөлөл**

Ерөнхий тэнцвэрийн загварыг ашиглан ЧХХ-ийн нөлөөллийг тооцохдоо дээр өгүүлсэн Hiro Lee, David Roland-Holst нарын аргачлалын дагуу 2 үе шат бүхий ЕТЭ-ыг ашигласан. Энэхүү судалгаанд ҮСХ-оос хамгийн сүүлд буюу 2013 онд тооцож гаргасан салбар хоорондын тэнцлийн мэдээллүүдийг авч ашигласан бөгөөд 2012 оны үзүүлэлтүүдийг суурь болгон тооцооллыг үйлдсэн. Эдгээр мэдээлэлд тулгуурлан улс орны эдийн засаг, үйлдвэрлэлийн технологид гарсан өөрчлөлт, Монголын эдийн засагт гадаадын улс орнууд, түүний дотор Япон улсын үзүүлж буй нөлөөлөл зэргийг нарийвчлан харуулахыг зорив.

Нэгдүгээр үе шатанд ҮСГ-аас 2013 онд шинэчлэн гаргасан 2010 оны салбар хоорондын тэнцлийн хүснэгт, Оюутолгой, Тавантолгойн ордуудын хөрөнгө оруулалтын мэдээллийг ашиглан 2025 он хүртэлх Монголын эдийн засгийн прогнозыг гаргасан. Тавантолгой, Оюутолгой зэрэг томоохон орд газруудын эдийн засагт үзүүлэх нөлөө асар өндөр байгаа тул Ерөнхий тэнцвэрийн загвараар ЭЗТХ-ийн эдийн засагт үзүүлэх нөлөөллийг судлахдаа ойрын жилүүдэд ашиглалтад орох эдгээр томоохон орд газруудын нөлөөллийг зайлшгүй авч үзэх шаардлагатай тулгарсан.

Прогнозыг 3 үндсэн хувилбараар тооцоолсон. Үүнд:

- Томоохон төслүүдийг ашиглалтад оруулаагүй нөхцөлд
- Оюутолгойн орд газрыг төслийн хүчин чадлаар нь ашиглах ба Тавантолгойгоос жилд 20 сая тн нүүрс олборлоно.
- Оюутолгойн орд газрыг төслийн хүчин чадлаар нь ашиглах ба Тавантолгойгоос жилд 40 сая тн нүүрс олборлоно.

<sup>10</sup> Edward M Feasel., “ Japan’s Aid: Lessons for Economic Growth, Development and Political Economy” Routledge, 2015, p 72

Эдгээр хувилбар тус бүрийн хувьд үнэ одоогийн түвшинд байхад, үнэ 20% өсөх буюу буурах гэсэн 3 өөр үнийн түвшинд прогнозыг тооцоолсон. Эдийн засгийн нөхцөл байдал үнийн өсөлтийн дээрх 3 өөр түвшинд байхад, түүнчлэн орд газруудыг ашиглалтад оруулсан буюу оруулаагүй байх ялгаатай нөхцлүүдэд Япон улстай ЭЗТХ байгуулснаар эдийн засагт ямар өөрчлөлт гарахыг тооцоолов.

Тооцоололд инфляцийн түвшинг Оюутолгой болон бусад томоохон төслүүдийн тооцоонд тусгасантай ижил түвшинд буюу жилийн 8% орчимд байхаар, хүн амын өсөлтийг өмнөх жилүүдийн дундаж түвшинд буюу жилийн 1.5% байхаар, алт, зэс, мөнгөний үнийг Оюутолгойн төслийн ТЭЗҮ-д тусгасан хэмжээнд байхаар, нүүрсний үнийг 2012 *kyu pgh* зээлийн үнийн түвшинд байхаар тооцоолсон.

Энэ судалгаанд Япон улстай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах боломжийг судалж, байгуулсан нөхцөлд эдийн засагт гарах өөрчлөлт болон хувилбаруудыг 2012, 2020, 2025 онуудаар авч үзсэн юм. Тэдгээр нь Оюутолгой, Таван толгойн орд газруудыг ашиглаагүй буюу ашигласны дараа Япон улстай ЭЗТХ байгуулах хувилбарууд юм.

ЭЗТХ-ийн нөлөөллийг тооцохоосоо өмнө бид Оюутолгой, Тавантолгой зэрэг томоохон орд газруудыг ашиглалтад оруулснаар Монголын эдийн засагт ямар өөрчлөлт гарах вэ гэдгийг дээр өгүүлсэн 3 үндсэн хувилбараар, үнийн 3 өөр түвшинд тооцож гаргасан. Тооцоог хавсралтад тусгав.

### **Симуляцийн үр дүн**


Юуны өмнө томоохон орд газруудыг ашиглалтад оруулж чадаагүй нөхцөлд Монголын эдийн засаг ямархуу байдалтай байх вэ гэдэг дүр зургийг авч үзье.

### **ДНБ**

Бидний судалгааны дүнгээс үзэхэд, хэрвээ томоохон төслүүдийг хэрэгжүүлж чадаагүй, өмнөх жилүүдийн эдийн засгийн өсөлтийн ерөнхий хандлага үргэлжилсэн хэвээр байна гэж үзвэл ДНБ-ий хэмжээ 2020 он гэхэд 91.0%-иар, 2025 он гэхэд 201.9%-иар өсөх тооцоо гарч байна. 2012 статистик мэдээллээс үзэхэд ам.долларын жилийн дундаж ханш 1359.4 төгрөг байсан ба ДНБ-ий хэмжээ 13.94 их наяд төгрөгт хүрсэн байна. Үүнийг нийт хүн амын тоонд хувааж үзвэл нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 4862.5 мянган төгрөг



буюу 3576.7 ам долларын хэмжээнд байна.



Хүн амын өмнөх 10 жилийн дундаж өсөлт хадгалагдаж, хүн ам жилд дунджаар 1.5%-иар өснө гэж үзвэл, нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 2020 он гэхэд 6157.5 ам.долларт, 2025 он гэхэд 9032.1 ам.долларт хүрэх тооцоо гарч байгаа юм.

Хэрвээ Оюутолгойн баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулж, Тавантолгойн төслийг хэрэгжүүлж, олборлолтыг жилийн 20 сая тн-д хүргэнэ гэж үзвэл, ДНБ-ий хэмжээ 2020 он гэхэд 191.1%-иар, 2025 он гэхэд 276.2%-иар тус тус өсч, нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 2020 онд 9382.5 ам.долларт, 2025 онд 11255.6 ам.долларт хүрэх тооцоо гарч байна. Гэхдээ өсөлтийн хэмжээ дэлхийн зах зээл дэх түүхий эдийн үнээс шууд хамааралтай байх бөгөөд үнэ 20%-иар буурна гэж үзвэл нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ

2020 онд 8565.4 ам.доллар, 2025 онд 10647.8 ам.долларын хэмжээнд байх төлөвтэй байна. Харин үнэ одоогийнхоос 20%-иар өсвөл, нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 2020 онд 10199.7 ам.долларт, 2025 онд 11863.5 ам.долларт хүрэхээр байна.

Тавантолгойн олборлолтын хэмжээг 40 сая тн-д хүртэл нэмэгдүүлж чадвал, 2012 оны үнийн түвшинд нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 2020 онд 10357.3 ам.долларт, 2025 он гэхэд 12160.4 ам.долларт хүрэх тооцоо гарч байна. Дэлхийн зах зээл дээр манай экспортын гол түүхий эдийн үнэ 20%-иар буурвал нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 2020 онд 9257.9 ам.доллар, 2025 онд 11290.7 ам.доллар, үнэ 20%-иар өсвөл 2020 онд 11456.6 ам.доллар, 2025 онд 13030.2 ам.долларын хэмжээнд хүрэхээр байна.

Хүснэгт 1. Монгол улсын ДНБ-ий өсөлтийн прогноз

Монгол улсын эдийн засгийн өсөлтийн прогноз							
	Томоохон төслүүдийг оруулахгүйгээр			ОТ + ТТ (20 сая тн)		ОТ + ТТ (40 сая тн)	
	2012	2020	2025	2020	2025	2020	2025
ДНБ-ий өсөлт / ДНБ 2012=1.0							
2012 оны үнийн түвшинд	1.0000	1.9105	3.0190	2.9112	3.7623	3.2136	4.0647
Үнэ 20% буурахад				2.6576	3.5591	2.8725	3.7740
Үнэ 20% өсөхөд				3.1647	3.9654	3.5547	4.3554
ДНБ-ий өсөлт / сая ам.доллараар							
2012 оны үнийн түвшинд	10257.6	19597.5	30968.1	29861.9	38592.0	32964.1	41694.2
Үнэ 20% буурахад				27261.0	36507.8	29465.2	38712.0
Үнэ 20% өсөхөд				32462.7	40676.1	36463.0	44676.4
Нэг хүнд ногдох ДНБ ам.доллараар /хүн ам 2012 онд 2867.7 мянга, жилийн дундаж өсөлт 1.5%							
2012 оны үнийн түвшинд	3577.0	6157.5	9032.1	9382.5	11255.6	10357.3	12160.4
Үнэ 20% буурахад				8565.4	10647.8	9257.9	11290.7
Үнэ 20% өсөхөд				10199.7	11863.5	11456.6	13030.2

ДНБ-ий бүтцийг авч үзвэл, олборлох үйлдвэрлэлийн болон бизнесийн үйлчилгээний салбарын эзлэх хувийн жин өсч, худалдааныхаас бусад салбарын эзлэх хувийн жин буурах төлөв ажиглагдаж байна.

Олборлох үйлдвэрлэлийн салбарын ДНБ-д эзлэх хувийн жин 2012 онд

21.9% байсан бол томоохон төсөл хөтөлбөрүүдийг ашиглалтад оруулснаар энэ хэмжээ 33.9 – 48.8%-д хүрч өсөх магадлалтай байна. Худалдааны салбарын ДНБ-д эзлэх хувийн жин 2012 онд 10.7% байсан бол энэ хэмжээ цаашид 10.4-14.8% орчимд байх төлөвтэй байгаа юм. Бизнесийн үйлчилгээний салбарын эзлэх хувийн жин 2012 онд 12.15% байсан бол энэ хэмжээ 9.3-28.4% орчимд хэлбэлзэх төлөвтэй байгаа юм ХАА, боловсруулах үйлдвэрлэл, барилга, тээвэр, харилцаа холбоо, нийгмийн үйлчилгээний салбаруудын хувьд ДНБ-д эзлэх хувийн жин нь буурах төлөвтэй байна.

Салбаруудын ДНБ-д эзлэх хувийн жингийн өөрчлөлтөд томоохон төслүүдийн хэрэгжилт, олборлолтын хэмжээ, экспортын гол нэрийн түүхий эдийн дэлхийн зах зээл дэх үнийн өөрчлөлт гэх мэт хүчин зүйлс нөлөөлж байна. Үүнийг доорх хүснэгтээс харж болно. Хүснэгт № 2-ыг үзнэ үү.

Япон улстай ЭЗТХ байгуулснаар ДНБ-ий хэмжээнд төдийлөн өндөр өөрчлөлт гарахгүй юм. Хэлэлцээр байгуулснаар ДНБ-ий хэмжээ 0.33-0.34%-иар өсөх бөгөөд өсөлтийн хэмжээг тоогоор илэрхийлбэл, томоохон орд газруудаас олборлох ашигт малтмалын хэмжээ, экспортын гол нэрийн бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт зэргээс хамаарч, 2020 онд 62.4 – 124.1 сая ам.доллар, 2025 онд 99.5 – 149.5 сая ам.доллараар өсөх магадлалтай байна.

ЭЗТХ-ийг байгуулснаар бий болох өсөлт салбар бүрт харилцан адилгүй байх бөгөөд барилгын салбарт хамгийн өндөр хэмжээнд буюу 0.47 – 0.48%, нийгмийн үйлчилгээний салбарт 0.39 – 0.40%, олборлох үйлдвэрлэлийн салбарт 0.38-0.39%, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 0.36 – 0.37%, бизнесийн үйлчилгээний салбарт 0.34 – 0.35%, тээвэр ба харилцаа холбооны салбарт 0.31 – 0.32%, эрчим хүч, усан хангамжийн салбарт 0.28 – 0.32%, худалдааны салбарт 0.24 – 0.25%, ХАА-н салбарт өсөлт хамгийн доогуур түвшинд буюу 0.17 – 0.18%-иар өсөх прогноз гарлаа.

## Хүснэгт 2. ДНБ-ийн салбарын бүтэц %-иар

ДНБ-ий салбарын бүтэц %-иар													
	2012	ОТ+ТТ1						ОТ+ТТ2					
		2020			2025			2020			2025		
		суурь онд	2012 оны үүний туршигд	үнэ 20% буурахад	үнэ 20% өсөхөд	2012 оны үүний туршигд	үнэ 20% буурахад	үнэ 20% өсөхөд	2012 оны үүний туршигд	үнэ 20% буурахад	үнэ 20% өсөхөд	2012 оны үүний туршигд	үнэ 20% буурахад
ХАА	14.8	8.4	9.2	7.7	9.2	9.7	8.7	7.6	8.5	6.9	8.5	9.1	7.9
Олборлох үйлдвэрлэл	18.6	40.5	35.9	44.4	27.7	24.2	30.8	45.1	39.9	49.3	32.2	27.9	36.0
Боловсруулах үйлдвэрлэл	6.2	2.6	2.8	2.4	2.5	2.7	2.4	2.3	2.6	2.1	2.3	2.5	2.2
Эрчим хүч, усан хангамж	2.0	1.4	1.5	1.2	2.2	2.3	2.1	1.2	1.4	1.1	2.1	2.2	1.9
Барилга	1.6	0.9	1.0	0.8	0.9	0.9	0.8	0.8	0.9	0.7	0.8	0.9	0.7
Бизнесийн үйлчилгээ	10.3	13.9	15.3	12.8	24.3	25.7	23.1	12.6	14.1	11.4	22.5	24.2	21.0
Худалдаа	9.1	10.6	11.6	9.8	11.4	12.0	10.8	9.6	10.7	8.7	10.5	11.3	9.8
Тээвэр, харилцаа холбоо	9.9	5.1	5.6	4.7	4.7	4.9	4.4	4.7	5.2	4.2	4.3	4.7	4.0
Нийгмийн үйлчилгээ	13.9	3.7	4.1	3.4	4.0	4.3	3.8	3.4	3.8	3.0	3.7	4.0	3.5
Шууд татвар	13.3	12.9	13.0	12.7	13.2	13.3	13.1	12.7	12.9	12.5	13.0	13.2	12.9

Эдгээрийг долларт шилжүүлбэл, уул уурхайн салбарын хувьд ЭЗТХ байгуулснаар ДНБ-ий үйлдвэрлэл нь 2020 он гэхэд 11.7 – 67.2 сая ам.доллар, 2025 он гэхэд 15.4 – 61.0 сая ам.доллараар өсөх тооцоо гарч байна. ДНБ-ий үйлдвэрлэлд 30 – 50%-ийг эзлэх уул уурхайн салбарт ЭЗТХ-ээс олох эдийн засгийн үр ашгийн хэмжээ ийм түвшинд байгаа бөгөөд бусад салбарт үнээс хавьгүй бага байх болно.

Хуримтлал болон цалингийн өсөлтийг шинээр бүтээсэн өртгийн өсөлттэй ижил түвшинд барина гэж үзвэл, эдийн засгийн салбаруудад цалин болон хуримтлал мөн дээрхтэй ойролцоо түвшинд өсөхөөр байна.

Онолын хувьд ЧХХ нь улс хоорондын худалдаанд улс орнууд өөрийн үйлдвэрлэлийн харьцангуй давуу талыг ашиглах боломжийг олгодог тул харьцангуй давуу тал бүхий бүтээгдэхүүнээ гадаад зах зээлд худалдан борлуулдаг салбаруудын үйлдвэрлэл борлуулалт бусдаас илүү хурдан өсөх боломжтой байдаг. Энэ утгаар нь харвал, ЭЗТХ-ийг байгуулснаар Монгол улсын үйлдвэрлэлийн харьцангуй давуу талыг хадгалсан ХАА-н болон уул уурхайн олборлох үйлдвэрлэлийн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл илүү хурдан өсөх ёстой юм.

Тооцооллоос үзэхэд, ЭЗТХ-ийг байгуулснаар олборлох үйлдвэрлэлийн салбарын ДНБ бусад салбаруудынхаас харьцангуй илүү өсөхөөр байгаа боловч ХАА-н салбарт өсөлт хамгийн доогуур түвшинд байна. Үүний шалтгаан нь Япон улсад нийлүүлж буй ХАА-н бүтээгдэхүүний экспорт хэмжээний хувьд бага байгаа тул ЭЗТХ-ийг байгуулснаар үүсэн бий болох эрэлтийн боломж ХАА-н салбарын үйлдвэрлэлд төдийлөн хүчтэй нөлөөлөхгүй гэдгийг харуулж байна.

ЭЗТХ байгуулсны дараа салбаруудын ДНБ-ий өсөлтөд гарч болох өөрчлөлтийн хувь хэмжээнээс харахад, үйлчилгээний зарим салбарт тухайлбал барилга, бизнесийн болон нийгмийн үйлчилгээний салбарт үйлдвэрлэлийн хэмжээ илүү хурдан өсөх магадлалтай байгаа нь анхаарал татаж байна. Магадгүй эдгээр салбар техник, технологийн хувьд Япон улсаас илүү хамааралтай байж болох. ЭЗТХ-ийн хүрээнд тарифыг бууруулснаар эдгээр техник технологийг худалдан авах зардал буурч, үйлчилгээний өртөг нь хямдарч, үйлдвэрлэлийнх нь хэмжээ өсөх тооцоо гарсан байж болох юм.

### **Үйлдвэрлэл**

Энэхүү судалгааны аргыг хийх явцад RAS аргыг ашиглан шинэчлэн тооцоолсон нийгмийн тооцооны матрицаас үзэхэд 2012 оны байдлаар Монгол улсын дотоодын нийт үйлдвэрлэлийн хэмжээ 17.07 тэрбум ам.долларын хэмжээнд байна. Төмөөхөн төслүүдийг ашиглаагүй нөхцөлд үйлдвэрлэлийн хэмжээ 2020 онд 33.3 тэрбум ам.долларт, 2025 онд 46.4 тэрбум ам.долларт орчимд байх тооцоо гарч байна. Оюутолгойн төслийг ашиглалтад оруулж, Тавантолгойн олборлолтыг 20 сая тн-д хүргэхэд дотоодын үйлдвэрлэлийн хэмжээ 2020 онд 46.5 тэрбум ам.долларт, 2025 онд 56.3 тэрбум ам.долларт хүрэхээр байна. Экспортын гол нэрийн барааны үнэ 20%-иар буурвал энэ хэмжээ 2020 онд 43.2 тэрбум ам.доллар, 2025 онд 53.7 тэрбум ам.доллар болж буурах төлөвтэй байгаа юм. Харин үнэ 20%-иар өсвөл дээрх хэмжээ 2015 онд 2020 онд 49.7 тэрбум ам.доллар, 2025 онд 59.0 тэрбум ам.доллар байх болно.

Хэрэв Тавантолгойн нүүрсний олборлолтын хэмжээг жилийн 40 сая тн-д хүргэвэл, дотоодын үйлдвэрлэлийн хэмжээ 2020 онд 50.6 тэрбум ам.долларт, 2025 онд 60.5 тэрбум ам.долларт хүрэх боломжтой. Энэ нөхцөлд хэрэв дэлхийн зах зээл дээр экспортын гол нэрийн түүхий эдийн үнэ 20%-иар унавал, дотоодын үйлдвэрлэлийн хэмжээ 2020 онд 46.2 тэрбум ам.доллар, 2020 онд 56.7 тэрбум ам.долларын хэмжээнд байх болно. Харин үнэ 20%-

иар өсвөл дотоодын үйлдвэрлэлийн хэмжээ 2020 онд 55.0 тэрбум ам.доллар, 2025 онд 64.3 тэрбум ам.долларын хэмжээнд байх юм.

Япон улстай ЭЗТХ байгуулсан нөхцөлд дотоодын үйлдвэрлэлийн хэмжээ 0.34%-иар буюу 2020 он гэхэд 113.0 – 187.8 сая ам.доллараар, 2025 он гэхэд 156.7 – 218.0 сая ам.доллараар өсөхөөр байна. Өсөлт ХАА-н салбарт харьцангуй доогуур хэмжээнд буюу 0.17 – 0.18% , бусад салбарт дунджаар 0.2 – 0.4%-тай байна.

### **Экспорт**

Япон улстай ЭЗТХ байгуулснаар Монгол улсын экспортын хэмжээ төдийлөн ихээр нэмэгдэхгүй юм. Бидний тооцоогоор ЭЗТХ байгуулснаар Монгол улсын нийт экспортын хэмжээ 0.36%-иар өсөх тооцоо гарч байгаа бөгөөд энэ өсөлт эдийн засгийн салбаруудад харилцан адилгүй хэмжээнд байна. Томоохон төсөл хөтөлбөрүүдийг ашиглалтад оруулж чадаагүй нөхцөлд уг хэлэлцээрийг байгуулснаар Монгол улсын нийт экспорт 2020 он гэхэд 35.2 сая ам.доллараар, 2025 он гэхэд 47.8 сая ам.доллараар өсөх тооцоо гарч байгаа юм. Оюутолгойн орд газрыг төслийн хүчин чадлаар нь ашиглалтад оруулж, Тавантолгойн орд газраас олборлох нүүрсний олборлолтыг жилийн 20 сая тн-д хүргэснээр экспорт 2020 он гэхэд 69.3 сая ам.доллараар, 2025 он гэхэд 73.4 сая ам.доллараар өсөхөөр байна. Гол нэрийн экспортын бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дээрх үнэ 20%-иар буурахад дээрх хэмжээ 2020 онд 60.8 сая ам.доллар хүртэл, 2025 он гэхэд 66.5 сая ам.доллар хүртэл харгалзан тус тус буурах, үнэ 20%-иар өсөхөд дээрх хэмжээ 2020 онд 77.6 сая ам.доллар хүртэл, 2025 онд 80.1 сая ам.доллар хүртэл тус тус өсөх тооцоо гарч байна.

Оюутолгойг төслийн хүчин чадлаар нь ашиглалтад оруулахын зэрэгцээ Тавантолгойн орд газраас жилд олборлох нүүрсний хэмжээг 40 сая тн хүртэл нэмэгдүүлсэн нөхцөлд гол нэрийн экспортын барааны дэлхийн зах зээлийн үнийн өсөлтөөс шалтгаалан ЭЗТХ-ийг байгуулснаар улсын нийт экспорт 2020 он гэхэд 68.1 – 90.5 сая ам.доллараар, 2025 он гэхэд 73.9 – 93.2 сая ам.доллараар өсөх төлөвтэй байгаа юм.

## Хүснэгт 3. ЭЗТХ-ийн экспортын өсөлтөд үзүүлэх нөлөөлөл

Хувилбарууд	Нийт экспортын өсөлт				Япон улсад хийх экспортын өсөлт			
	Өөрчлөлт %-иар		сая ам.доллар		Өөрчлөлт %-иар		сая ам.доллар	
	2020	2025	2020	2025	2020	2025	2020	2025
Томоохон төсөл, хөтөлбөрүүдийг тооцоонд оруулахгүйгээр								
2012 оны үнийн түвшинд	0.3568	0.3553	35.158	47.831	5.5513	5.6853	0.2304	0.2985
Оюутолгой + Тавантолгой (жилийн олборлолт 20 сая тн)								
2012 оны үнийн түвшинд	0.3625	0.3604	69.271	73.373	5.1630	5.4298	0.2495	0.3127
Үнэ 20%-иар буурахад	0.3624	0.3596	60.838	66.542	5.2463	5.4903	0.2449	0.3091
Үнэ 20%-иар өсөхөд	0.3622	0.3608	77.623	80.151	5.0852	5.3718	0.2540	0.3163
Оюутолгой + Тавантолгой (жилийн олборлолт 40 сая тн)								
2012 оны үнийн түвшинд	0.3616	0.3604	79.351	83.567	5.0593	5.3347	0.2556	0.3187
Үнэ 20%-иар буурахад	0.3620	0.3600	68.109	73.880	5.1643	5.4171	0.2494	0.3134
Үнэ 20%-иар өсөхөд	0.3608	0.3603	90.469	93.160	4.9631	5.2572	0.2618	0.3239

ЭЗТХ-ийг байгуулснаар улсын жилийн нийт экспорт 0.36 орчим хувиар өсөх бол Япон улсад хийх нийт экспорт жилийн 4.9 – 5.5 орчим хувь өсөх тооцоо гарч байна. Хэдийгээр ЭЗТХ-ийг байгуулснаар Япон улсад хийх экспортын өсөлтийн хувь нь харьцангуй өндөр байх тооцоо гарч байгаа боловч томоохон төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилт, экспортын гол нэрийн барааны дэлхийн зах зээл дэх үнийн өөрчлөлт зэргээс шалтгаалан хэмжээний хувьд жилд дөнгөж 0.2 – 0.3 сая ам.доллараар өсөхөөр байна.

Энэ нь нэгд, Япон улсад хийж буй экспортын хэмжээ бага, жилийн 5 – 6 сая доллараас хэтрэхгүй байгаатай, хоёрт, Япон улсад хийж буй манай экспортын бүтээгдэхүүнүүд үнийн мэдрэмжгүй байгаатай, гуравт, Япон улс ЭЗТХ-ийг байгуулснаар манай зүгээс экспортыг нь нэлээд ихээр нэмэгдүүлэх боломжтой хэмээн найдлаг тавьж буй ХАА-н салбараа тарифын гэхээс илүүтэйгээр тарифын бус аргаар хамгаалж байгаатай холбоотой юм.

Тиймээс хэрэв ЭЗТХ-ээс илүү үр шимийг хүртэнэ гэж үзвэл хэлэлцээрийн хүрээнд Япон улсын зүгээс ХАА-н бүтээгдэхүүнд тавьж буй тарифын бус хориг саадууд, түүний дотор мал эмнэлэг, ариун цэвэр, ургамлын хорио

цээрийн болон бүтээгдэхүүний стандартын шаардлагуудыг сулруулах чиглэлд хэлцэл хийх шаардлагатай байгаа юм.

### **Хэрэглээ**

ЧХХ байгуулснаар түншлэгч талууд өөр хоорондоо худалдаалж буй барааныхаа 90-ээс доошгүй хувийг гаалийн татвараас чөлөөлөх ба ингэснээр зах зээлд бараа үйлчилгээний үнэ буурах үзэгдэл ажиглагдана. Үнийн энэхүү бууралтаас шалтгаалан мэдрэмж өндөртэй барааны хэрэглээ хурдан өсч, мэдрэмж багатай барааных харьцангуйгаар удаан өсдөг тул хэлэлцээр байгуулснаар дотоодын хэрэглээнд зарим нэг өөрчлөлт гарах магадлалтай юм.

Хэрвээ импортын бараа дотоодын бараанаас үнийн мэдрэмж өндөртэй бол ЭЗТХ байгуулснаар импортын барааны эрэлт өсч, нийлүүлэлт нь нэмэгдэнэ. Учир нь хэлэлцээр байгуулснаар тариф буурч, тарифын бууралт нь импортын зардлыг бууруулж, үнийг хямдруулах боломж олгодог. Үүнтэй зэрэгцэн дотоодод үйлдвэрлэсэн барааны зах зээлд эзлэх хувь буурч, дотоодын үйлдвэрлэлд хор хохирол учирдаг. Харин импортын бараа мэдрэмж багатай байхад ЭЗТХ байгуулахын ач холбогдол бага байх болно. Учир нь мэдрэмж багатай барааны хувьд үнэ 1%-иар буурахад нийлүүлэлт түүнээс бага хувиар өснө.

Манай орны хувьд экспорт импортын аль аль нь ерөнхийдөө мэдрэмж муутай байдаг. Энэ нь нэг талаас импортыг орлох үйлдвэрлэл хөгжөөгүйтэй, нөгөө талаас дотоодын зах зээл нь хэт жижиг тул үйлдвэрлэсэн илүүдэл бүтээгдэхүүнээ ямар ч үнээр болов зарахад бэлэн байдаг зэрэгтэй холбоотой.

2012 оны байдлаар Монгол улсын нийт хэрэглээ 21.47 тэрбум доллар байсан үүний 57.36%-ийг буюу 12.31 тэрбум долларын хэрэглээг дотоодын үйлдвэрлэлийн бараа үйлчилгээгээр, 42.64%-ийг буюу импортын бараа үйлчилгээгээр хангасан байна. Нийт хэрэглээний 2.23%, нийт импортын 5.25%-ийг Япон улсаас импортлосон бараагаар хангажээ. Мөн онд хэрэглэсэн барааны 31.7%-ийг үйлдвэрлэлийн зориулалтаар буюу завсрын хэрэглээнд, 68.3%-ийг эцсийн хэрэглээнд зарцуулсан байна.



## Хүснэгт 4. Дотоодын нийт хэрэглээ ЭЗТХ-ийн өмнө ба хойно

Хувилбарууд	Нийт хэрэглээ							
	ЭЗТХ байгуулаагүй нөхцөлд сая ам.долл		ЭЗТХ байгуулснаар сая ам.долл		Өөрчлөлт сая ам.долл		Өсөлт %-иар	
	2020	2025	2020	2025	2020	2025	2020	2025
Томоохон төсөл, хөтөлбөрүүдийг тооцоонд оруулахгүйгээр								
2012 оны үнийн түвшинд	29076.0	34874.3	29137.9	34948.6	61.88	74.22	0.213	0.213
Оюутолгой + Тавантолгой (жилийн олборлолт 20 сая тн)								
2012 оны үнийн түвшинд	40763.7	44049.1	40844.6	44138.3	80.94	89.18	0.199	0.202
Үнэ 20%-иар буурахад	38072.4	41864.5	38148.9	41950.1	76.55	85.62	0.201	0.205
Үнэ 20%-иар өсөхөд	43455.0	46233.8	43540.3	46326.6	85.32	92.74	0.196	0.201
Оюутолгой + Тавантолгой (жилийн олборлолт 40 сая тн)								
2012 оны үнийн түвшинд	44763.0	48041.4	44850.4	48137.1	87.45	95.69	0.195	0.199
Үнэ 20%-иар буурахад	41049.9	44835.0	41131.3	44925.5	81.40	90.46	0.198	0.202
Үнэ 20%-иар өсөхөд	48476.0	51247.8	48569.5	51348.7	93.51	100.91	0.193	0.197

Бидний тооцооноос үзэхэд, ЭЗТХ-ийг байгуулснаар дотоодын үнэ ялимгүй буурч, үүнийг дагалдан дотоодын барааны хэрэглээ бага зэрэг өсөх тооцоо гарч байна.

Монгол улсын дотоодын хэрэглээ ЭЗТХ-ийг байгуулснаар ойролцоогоор 0.2 орчим хувиар өсөх ба өсөлт нь томоохон төслүүдийн хэрэгжилт, экспортын гол нэрийн барааны дэлхийн зах зээл дэх үнийн өөрчлөлт зэргээс хамаарч, 2015 он гэхэд 51.9 – 73.5 сая ам.доллар, 2020 он гэхэд 61.9 – 93.5 сая ам.доллар, 2025 он гэхэд 74.2 – 100.9 сая ам.доллар орчимд байх прогноз гарч байна.

## Хүснэгт 5. Дотоодын үйлдвэрлэлийн барааны хэрэглээ

Хувилбарууд	Дотоодын үйлдвэрлэлийн барааны хэрэглээ							
	ЭЗТХ байгуулаагүй нөхцөлд		ЭЗТХ байгуулснаар сая ам.долл		Өөрчлөлт сая ам.долл		Өсөлт %-иар	
	2020	2025	2020	2025	2020	2025	2020	2025
Томоохон төсөл, хөтөлбөрүүдийг тооцоонд оруулахгүйгээр								
2012 оны үнийн түвшинд	16243.2	19482.4	16251.5	19492.4	8.34	10.00	0.051	0.051
Оюутолгой + Тавантолгой (жилийн олборлолт 20 сая тн)								
2012 оны үнийн түвшинд	20616.2	22915.2	20627.2	22927.3	11.03	12.11	0.053	0.053

Үнэ 20%-иар буурахад	19609.2	22097.8	19619.6	22109.4	10.41	11.61	0.053	0.053
Үнэ 20%-иар өсөхөд	21623.2	23732.6	21634.8	23745.2	11.65	12.62	0.054	0.053
Оюутолгой + Тавантолгой (жилийн олборлолт 40 сая тн)								
2012 оны үнийн түвшинд	22112.6	24408.9	22124.5	24422.0	11.95	13.03	0.054	0.053
Үнэ 20%-иар буурахад	20723.3	23209.2	20734.4	23221.5	11.09	12.29	0.054	0.053
Үнэ 20%-иар өсөхөд	23501.8	25608.6	23514.6	25622.4	12.80	13.77	0.054	0.054

ЭЗТХ байгуулснаар нийт хэрэглээ 0.2%-иар өсөх төлөвтэй байгаа бол завсрын буюу үйлдвэрлэлийн хэрэглээ 0.34 – 0.36%-иар өсөх тооцоо гарсан. Үүнээс үзэхэд, Япон улсаас худалдан авдаг импортын барааны бүтцэд үйлдвэрлэлийн зориулалттай барааны эзлэх хувийн жин өсөх болов уу гэсэн таамаглалыг хийж болохоор байна. /Хүснэгт №6/ Завсрын буюу үйлдвэрлэлийн зориулалттай барааны хэрэглээ өсөхийн хэрээр хувийн буюу эцсийн хэрэглээ буурах болно. Энэ хэрээр одоо импортын бүтцэд 70 гаруй хувийг эзэлж буй тээврийн хэрэгслийн эзлэх хувийн жин буурч, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, машин механизмын эзлэх хувийн жин өснө. Учир нь ийм төрлийн барааг агуулдаг барааны бүлгүүдэд импортын үнийн мэдрэмж харьцангуй өндөр байна.

#### Хүснэгт 6. Завсрын буюу үйлдвэрлэлийн хэрэглээ

Хувилбарууд	Завсрын буюу үйлдвэрлэлийн хэрэглээ							
	ЭЗТХ байгуулаагүй нөхцөлд сая ам.долл		ЭЗТХ байгуулснаар сая ам.долл		Өөрчлөлт сая ам.долл		Өсөлт %-иар	
	2020	2025	2020	2025	2020	2025	2020	2025
Томоохон төсөл, хөтөлбөрүүдийг тооцоонд оруулахгүйгээр								
2012 оны үнийн түвшинд	16378.8	19645.1	16438.7	19716.9	59.85	71.78	0.365	0.365
Оюутолгой + Тавантолгой (жилийн олборлолт 20 сая тн)								
2012 оны үнийн түвшинд	20461.2	22849.7	20533.2	22931.0	71.99	81.31	0.352	0.356
Үнэ 20%-иар буурахад	19521.1	22086.6	19590.3	22165.7	69.19	79.04	0.354	0.358
Үнэ 20%-иар өсөхөд	21401.2	23612.8	21476.0	23696.4	74.78	83.58	0.349	0.354
Оюутолгой + Тавантолгой (жилийн олборлолт 40 сая тн)								
2012 оны үнийн түвшинд	21858.1	24244.2	21934.2	24329.6	76.14	85.46	0.348	0.352
Үнэ 20%-иар буурахад	20561.1	23124.2	20633.4	23206.3	72.29	82.13	0.352	0.355
Үнэ 20%-иар өсөхөд	23155.0	25364.1	23235.0	25452.9	80,00	88,79	0.346	0.350

## Импорт

ЭЗТХ-ийг байгуулснаар нийт хэрэглээ 0.2% орчимд өсөх тооцоо гарсан бол дотоодын үйлдвэрлэлийн барааны хэрэглээ 0.05%-иар, импортын барааны хэрэглээ 0.32 – 0.42%-иар өсөх тооцоо гарсан. Импортын өсөлт дотоодын үйлдвэрлэлийн өсөлтөөс харьцангуй өндөр байх тул нийт хэрэглээнд дотоодын үйлдвэрлэлийн барааны эзлэх хувийн жин буурах болно.

Хүснэгт 7. Импортын хэрэглээний өсөлт

Хувилбарууд	Импортын барааны хэрэглээ							
	ЭЗТХ байгуулаагүй нөхцөлд сая ам.долл		ЭЗТХ байгуулснаар сая ам.долл		Өөрчлөлт сая ам.долл		Өсөлт %-иар	
	2020	2025	2020	2025	2020	2025	2020	2025
Томоохон төсөл, хөтөлбөрүүдийг тооцоонд оруулахгүйгээр								
2012 оны үнийн түвшинд	12832.8	15392.0	12886.4	15456.2	53.54	64.22	0.417	0.417
Оюутолгой + Тавантолгой (жилийн олборлолт 20 сая тн)								
2012 оны үнийн түвшинд	20147.5	21133.9	20217.4	21211.0	69.91	77.07	0.347	0.365
Үнэ 20%-иар буурахад	18463.1	19766.7	18529.3	19840.7	66.14	74.01	0.358	0.374
Үнэ 20%-иар өсөхөд	21831.8	22501.2	21905.5	22581.3	73.68	80.12	0.337	0.356
Оюутолгой + Тавантолгой (жилийн олборлолт 40 сая тн)								
2012 оны үнийн түвшинд	22650.4	23632.5	22725.9	23715.1	75.51	82.66	0.333	0.350
Үнэ 20%-иар буурахад	20326.6	21625.8	20396.9	21703.9	70.31	78.17	0.346	0.361
Үнэ 20%-иар өсөхөд	24974.2	25639.2	25054.9	25726.3	80.71	87.15	0.323	0.340

ЭЗТХ байгуулснаар дотоодын үйлдвэрлэлийн барааны хэрэглээ 2020 онд 8.3 – 12.8 сая доллараар, 2025 онд 10.0 – 13.8 сая доллараар өсөх тооцоо гарч байгаа бол импортын хэрэглээ 2020 онд 53.5 – 80.7 сая доллараар, 2025 онд 64.2 – 87.1 сая ам.доллараар өсөх юм. Эдгээр өсөлтөд томоохон төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилт, гол нэрийн экспортын барааны дэлхийн зах зээл дэх үнийн өөрчлөлт шууд нөлөөлөх болно.

ЭЗТХ байгуулснаар Япон улсаас импортлох импорт нийт импортоос илүү хурдан өсөх тооцоо гарч байна. Тухайлбал, хэлэлцээрийг байгуулснаар нийт импорт 0.32 – 0.42%-иар өсөх бол Япон улсаас импортлох импорт 3.79 – 3.84%-иар өсөх төлөвтэй байна.

## Хүснэгт 8. Япон улсаас импортлох импорт

Хувилбарууд	Японоос импортлох импорт											
	ЭЗТХ байгуулаагүй нөхцөлд сая ам.долл			ЭЗТХ байгуулснаар сая ам.долл			Өөрчлөлт сая ам.долл			Өсөлт %-нар		
	2015	2020	2025	2015	2020	2025	2015	2020	2025	2015	2020	2025
Томоохон төсөл, хөтөлбөрүүдийг тооцоонд оруулахгүйгээр												
2012 оны үнийн түвшинд	846.1	1014.8	1217.2	878.5	1053.7	1263.9	32.46	38.93	46.69	3.836	3.836	3.836
Оюутолгой + Тавантолгой (жилийн олборлолт 20 сая тн)												
2012 оны үнийн түвшинд	966.9	1217.0	1375.9	1003.8	1263.3	1428.4	36.87	46.31	52.49	3.813	3.806	3.815
Үнэ 20%-нар буурахад	941.9	1170.4	1338.1	977.8	1215.0	1389.2	35.96	44.61	51.11	3.817	3.812	3.819
Үнэ 20%-нар өсөхөд	992.0	1263.5	1413.7	1029.8	1311.5	1467.5	37.79	48.01	53.87	3.809	3.800	3.811
Оюутолгой + Тавантолгой (жилийн олборлолт 40 сая тн)												
2012 оны үнийн түвшинд	1036.3	1286.2	1444.9	1075.7	1335.0	1500.0	39.40	48.84	55.01	3.802	3.797	3.807
Үнэ 20%-нар буурахад	993.6	1221.9	1389.5	1031.4	1268.4	1442.5	37.84	46.49	52.99	3.809	3.805	3.813
Үнэ 20%-нар өсөхөд	1079.0	1350.4	1500.4	1120.0	1401.6	1557.4	40.96	51.19	57.04	3.797	3.791	3.802

Томоохон төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилт, гол нэрийн экспортын барааны дэлхийн зах зээлийн үнэ зэргээс шалтгаалан нийт хэрэглээнд импортын эзлэх хувийн жин 42.6 – 44.1% хүртэл өсөх, 51.6% хүртэл өсөх магадлалтай байгаа ба ЭЗТХ нийт хэрэглээнд импортын эзлэх хувийн жинг 0.1%-иар нэмэгдүүлэх болно.

Хэлэлцээр байгуулагдсанаар Монгол улсын Япон улсаас худалдан авдаг импортын хэмжээ 2015 он гэхэд 32.5 – 41.0 сая ам.доллараар, 2020 он гэхэд 38.9 – 51.2 сая ам.доллараар, 2025 он гэхэд 46.7 – 57.0 сая ам.доллараар тус тус өсөх юм.

Нийт импортод Япон улсаас худалдан авах барааны эзлэх хувийн жин 2012 онд 5.2%-ийг эзэлж байсан бол ЭЗТХ-ийг байгуулснаар энэ хувь хэмжээ 8.2% хүртэл нэмэгдэх боломжтой. Тооцооноос үзэхэд, Монгол улсад олборлох үйлдвэрлэлийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ өсөхийн хэрээр нийт импортод Япон улсын эзлэх хувийн жин багасах хандлагатай байна. Энэ нь Монгол улсын уул уурхайн салбарын үйлдвэрлэлд Японы тоног төхөөрөмжийн хэрэглээ харьцангуй бага байдагтай холбоотой байж болох юм.

## Хүснэгт 9. Импортын хувийн жингийн өөрчлөлт

Хувилбарууд	Нийт хэрэглээнд импортын эзлэх хувийн жин /%-оор					Нийт импортод Япон улсын эзлэх хувийн жин %				
	ЭЗТХ байгуулаагүй нөхцөлд			ЭЗТХ байгуулснаар		ЭЗТХ байгуулаагүй нөхцөлд			ЭЗТХ байгуулснаар	
	2012	2020	2025	2020	2025	2012	2020	2025	2020	2025
Томоохон төсөл, хөтөлбөрүүдийг тооцоонд оруулахгүйгээр										
2012 оны үнийн түвшинд	42.6	44.1	44.1	44.2	44.2	5.2	7.9	7.9	8.2	8.2
Оюутолгой + Тавантолгой (жилийн олборлолт 20 сая тн)										
2012 оны үнийн түвшинд		49.4	48.0	49.5	48.1		6.0	6.5	6.2	6.7
Үнэ 20%-иар буурахад		48.5	47.2	48.6	47.3		6.3	6.8	6.6	7.0
Үнэ 20%-иар өсөхөд		50.2	48.7	50.3	48.7		5.8	6.3	6.0	6.5
Оюутолгой + Тавантолгой (жилийн олборлолт 40 сая тн)										
2012 оны үнийн түвшинд		50.6	49.2	50.7	49.3		5.7	6.1	5.9	6.3
Үнэ 20%-иар буурахад		49.5	48.2	49.6	48.3		6.0	6.4	6.2	6.6
Үнэ 20%-иар өсөхөд		51.5	50.0	51.6	50.1		5.4	5.9	5.6	6.1

ЭЗТХ байгуулснаар улсын гадаад худалдааны тэнцэлд төдийлөн их өөрчлөлт гарахгүй юм. Томоохон төсөл хөтөлбөрүүдийг ашиглалтад оруулж чадаагүй нөхцөлд 2012 оны үнийн түвшинд уг хэлэлцээрийг байгуулснаар гадаад худалдааны алдагдал 2020 он гэхэд 18.4 сая доллараар, 2025 он гэхэд 16.4 сая ам.доллараар нэмэгдэх тооцоо гарсан. Гэхдээ Оюутолгой, Тавантолгойн орд газруудыг эргэлд оруулж, олборлолтыг нэмэгдүүлэхийн хэрээр, дэлхийн зах зээлд экспортын гол нэрийн бүтээгдэхүүний үнэ өсөхийн хэрээр уг алдагдал багасч, тэнцэл сайжрах болно.

Гадаад худалдааны тэнцлийн прогнозоос үзэхэд, уул уурхайн салбарын үйлдвэрлэл өсөхийн хэрээр Япон улсын манай импортод эзлэх хувийн жин буурч, экспортод Япон улсын эзлэх хувийн жин өсөх хандлага ажиглагдаж байна. Тиймээс ЗГ уул уурхайн томоохон орд газруудыг ашиглах төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж буй нөхцөлд ЭЗТХ байгуулах нь ерөнхийдөө худалдааны тэнцэлд эерэг нөлөөтэй болно.

**Хүснэгт 10. Гадаад худалдааны тэнцлийн төлөв байдалд  
гарах өөрчлөлт / сая ам.доллар**

ЭЗТХ байгуулснаар худалдааны тэнцэлд гарах өөрчлөлт						
Хувилбарууд	Экспортод гарах өөрчлөлт		Импортод гарах өөрчлөлт		Тэнцэлд гарах өөрчлөлт	
	2020	2025	2020	2025	2020	2025
Томоохон төсөл, хөтөлбөрүүдийг тооцоонд оруулахгүйгээр						
2012 оны үнийн түвшинд	35.2	47.8	53.5	64.2	-18.4	-16.4
Оюутолгой + Тавантолгой (жилийн олборлолт 20 сая тн)						
2012 оны үнийн түвшинд	69.3	73.4	69.9	77.1	-0.6	-3.7
Үнэ 20%-иар буурахад	60.8	66.5	66.1	74.0	-5.3	-7.5
Үнэ 20%-иар өсөхөд	77.6	80.2	73.7	80.1	3.9	0.0
Оюутолгой + Тавантолгой (жилийн олборлолт 40 сая тн)						
2012 оны үнийн түвшинд	79.4	83.6	75.5	82.7	3.8	0.9
Үнэ 20%-иар буурахад	68.1	73.9	70.3	78.2	-2.2	-4.3
Үнэ 20%-иар өсөхөд	90.5	93.2	80.7	87.1	9.8	6.0

**Төсөв**

ЭЗТХ байгуулснаар улсын төсвийн орлого 2020 он гэхэд 35.1 – 43.3 сая ам.доллараар, 34.8 – 42.3 сая ам.доллараар тус тус буурах тооцоо гарч байна. Төсвийн орлого буурахад нөлөөлөх гол хүчин зүйл нь импортын татварын орлогын бууралт юм. ЭЗТХ байгуулснаар Япон улсаас импортлох барааны 90-ээс дээш хувийг импортын татвараас чөлөөлөхтэй холбоотойгоор жил бүр 44.6 – 87.1 сая ам.долларын орлого улсын төсөвт оруулах боломжийг алдах юм.

**Хүснэгт 11. Улсын төсвийн орлогод гарах өөрчлөлт / сая ам.доллар**

Улсын төсвийн орлого						
Хувилбарууд	ЭЗТХ байгуулаагүй нөхцөлд		ЭЗТХ байгуулснаар		Өөрчлөлт	
	2020	2025	2020	2025	2020	2025
Томоохон төсөл, хөтөлбөрүүдийг тооцоонд оруулахгүйгээр						
2012 оны үнийн түвшинд	6455.3	9982.7	6420.2	9948.0	-35.12	-34.76
Оюутолгой + Тавантолгой (жилийн олборлолт 20 сая тн)						
2012 оны үнийн түвшинд	9910.2	12561.1	9870.5	12522.2	-39.78	-38.98
Үнэ 20%-иар буурахад	9041.5	11864.3	9002.6	11826.0	-38.94	-38.27
Үнэ 20%-иар өсөхөд	10779.0	13258.0	10738.3	13218.3	-40.65	-39.70

Оюутолгой + Тавантолгой (жилийн олборлолт 40 сая тн)						
2012 оны үнийн түвшинд	10966.0	13616.8	10924.1	13575.6	-41.97	-41.13
Үнэ 20%-иар буурахад	9795.1	12617.7	9754.4	12577.7	-40.66	-39.98
Үнэ 20%-иар өсөхөд	12137.0	14615.8	12093.7	14573.5	-43.31	-42.32

Ерөнхийдөө Япон улстай ЭЗТХ байгуулснаар Монгол улсын дотоодын үйлдвэрлэл, хэрэглээний аль аль нь багахан хэмжээнд өсөх тооцоо гарч байгаа бөгөөд өсөлтийн хэмжээнд гадаад худалдааны нийт эргэц, худалдаж буй барааны үнийн мэдрэмж зэрэг хүчин зүйлс нөлөөлж байна.

ЭЗТХ байгуулснаар нийт хэрэглээ 0.2%-иар өсөх тооцоо гарч байгаа бол завсрын буюу үйлдвэрлэлийн хэрэглээ 0.34 – 0.36%, дотоодын үйлдвэрлэлийн барааны хэрэглээ 0.05%, импортын хэрэглээ 0.32 – 0.42%, Япон улсаас импортлох импорт 3.8%-иар тус тус өсөх тооцоо гарсан. Харин уг хэлэлцээрийг байгуулснаар нийт үйлдвэрлэл 0.34%, ДНБ 0.34 – 0.35%, нийт экспорт 0.36%, Япон улсад нийлүүлэх экспорт 4.9 – 5.5% өсөх тооцоо гарсан.

Япон улстай ЭЗТХ байгуулснаар Монголд улсын ДНБ-ий өсөлтөд тийм ч хүчтэй нөлөөлөл үзүүлэхгүй нь тооцооноос харагдаж байна. Хэлэлцээрийг байгуулснаар үйлдвэрлэл нь хэрэглээнээсээ ялимгүй хурдан өсөхөөр байгаа юм. Өөрөөр хэлбэл, ЭЗТХ байгуулснаар зах зээл дэх барааны нийлүүлэлт эрэлтээсээ ялимгүй хурдан өсөх нөхцөл боломж бүрдэж, дотоодын зах зээл дэх эрэлт нийлүүлэлтийн тэнцэл бага зэрэг сайжрах нөхцлийг бүрдүүлнэ. Харин гадаад төлбөрийн тэнцэл талаасаа үзвэл уул уурхайн олборлолтын хэмжээг нэмэгдүүлэхийн хэрээр ЭЗТХ Монгол улсад ашигтай байх магадлалтай байна.

Ерөнхий тэнцвэрийн загвар суурилсан шинжилгээний үр дүнг ерөнхийд нь дүгнэж үзэхэд, Япон улстай ЭЗТХ байгуулснаар манай эдийн засагт томоохон өөрчлөлт гарахгүй, хоёр орны хоорондох худалдааны хэмжээ бага байх нь илэрхий байна. Олон улсын практикт иймэрхүү хэлэлцээрийг байгуулсан жишээ олон байдаг бөгөөд тэдгээрийг ерөнхийд нь “худалдаа багатай ЧХХ” буюу “trade less FTA” гэж нэрлэдэг.

### **ЭЗТХ-ийн үр дүн ба эдийн засгийн хамтын ажиллагааны шинэ боломжууд**

Даяаршил болон дэлхийн эдийн засгийн интеграцчиллын үр дүнд түргэн хурдацтай өөрчлөгдөж буй орчин нөхцөлд найрсаг харилцаа, харилцан ашигтай

хамтын ажиллагаагаа бэхжүүлэх, хоорондын худалдаа, хөрөнгө оруулалтын тааламжтай орчин бүрдүүлэх замаар эдийн засагт байгаа хүч нөөцөө үр дүнтэй ашиглах, харилцан бие биеэ нөхөх, эдийн засгийн өрсөлдөх чадвараа дээшлүүлэх зорилгод нэгдсэн Монгол, Япон улсууд урт удаан хугацааны гэрээ хэлэлцээр хийж, долоон удаагийн уулзалт хэлэлцээр явуулсны дүнд 2015 оны 2-р сарын 10-ны өдөр ЭЗТХ байгуулав.

ЭЗТХ-т хоёр орны хооронд бараа, үйлчилгээний худалдааг чөлөөлөх ба хөнгөвчлөх; хувь хүний шилжилт хөдөлгөөнийг хөнгөвчлөх; хөрөнгө оруулалтын боломжуудыг нэмэгдүүлэх, талуудын хөрөнгө оруулалт түүнтэй холбогдох үйл ажиллагааны хамгаалалтыг бэхжүүлэх; оюуны өмчийн хамгаалалтыг сайжруулах; өрсөлдөөний хууль тогтоомжийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд чиглэсэн хамтын ажиллагаа, уялдааг дэмжих; худалдаа, хөрөнгө оруулалтад хамааралтай бүх салбарт хоёр талын хамтын ажиллагааг цаашид эрчимжүүлэх, өргөтгөн гүнзгийрүүлж, бизнесийн орчныг сайжруулах хүрээг тодорхойлох зэрэг асуудлыг тусгасан.

ТХЕХ-ийн XXIV 8(б)-ийн дагуу ЧХХ-т оролцогч улс орнууд гаалийн тарифаа тэглэх барааны үнийн дүнгийн хувь хэмжээг тохирдог. Олон улсын туршлагаас үзэхэд ЧХХ хүчин төгөлдөр болох үед нийт үнийн дүнгийн дор хаяж 50 хувьтай тэнцэх хэмжээний барааны гаалийн тарифыг тэглэсэн байдаг. Харин Япон улстай байгуулсан ЭЗТХ-ээр манай талаас экспортлох боломжтой 5700 нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг, Японы талаас манайд экспортлох боломжтой 9300 нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг импортын гаалийн татварыг “тэглэх” буюу үе шаттайгаар бууруулахаар тохиролцсон.

2016 оны 6-р сарын 7-ноос хэрэгжиж эхлэх уг хэлэлцээрийн дагуу манайхаас худалдах боломжтой бараа бүтээгдэхүүнүүд болох бог малын маханд ногдуулдаг 38.5%-ийн, ноос ноолуурын 3-8%-ийн, арьс, ширний 20%-ийн, арьс ширээр хийсэн бүтээгдэхүүнд ногдуулдаг 3%-ийн, оёмол болон нэхмэл сүлжмэлийн 10-30%-ийн, цэвэршүүлсэн зэс болон коксод ногдуулдаг 3%-ийн гаалийн татварууд тэглэгдсэн. Ингэснээр манай бизнес эрхлэгчид Японы зах зээлд үндэсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээ гаалийн татварын хөнгөлөлттэй нөхцлөөр худалдаалах боломж бүрдэж байна.

Хэлэлцээрт манай оронд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чухал хэрэгцээтэй дэвшилтэт техник, технологийг чөлөөтэй нэвтрэх боломжийг бүрдүүлэх асуудалд анхаарч, хөрөнгө оруулалтын боломжуудыг сайжруулах, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг хамгаалах



асуудлыг талууд тусгайлан авч үзсэний зэрэгцээ Монголын тал Япон улсаас импортлох үйлдвэрлэлийн зориулалттай болон техник, технологийн багтаамж өндөртэй бараа, түүний дотор БТКУС-ын 81 – 90-р бүлгийн барааг татвараас чөлөөлөхөөр болсон. Одоогийн байдлаар тус улсаас импортлож буй барааны дийлэнх хэсгийг үнийн мэдрэмжгүй, дотоодод үйлдвэрлэх боломжгүй бараа бүтээгдэхүүнүүд эзэлдэг. Тухайлбал тус улсаас импортлож буй барааны 4/3 орчим хувийг тээврийн хэрэгсэл, үлдэх хэсгийг уул уурхайн хүнд машин механизмууд, машины дугуй, тамхи зэрэг бараа эзэлж байна.

Хэлэлцээрийг ерөнхийд нь дүгнэж үзэхэд, хоёр орны хооронд ЭЗТХ байгуулснаар Монгол богино хугацаанд үр өгөөжийг нь хүртэж чадахгүй боловч урт хугацаанд манай экспортлогчдод томоохон боломжууд үүсч, Японы асар том зах зээлд бизнес эрхлэх тааламжтай орчин бүрдлээ. Ялангуяа экспорт, импортын харьцангуй давуу талын давхцал, Япон улсын дэлхийн импортод эзэлж буй байр суурь зэргээс үзэхэд мал эмнэлэг, эрүүл ахуй, хорио цээрийн талын бэрхшээлүүдээ шийдвэрлэж чадвал бог малын мах, малын гаралтай хүнсний бүтээгдэхүүн, түүхий эдийг тус улсад экспортлох боломжтой болж байна.

Гангийн үйлдвэрлэлийн хэмжээгээр дэлхийд хоёрт ордог Япон улс ганг хайлуулахад шаардлагатай коксжих нүүрсний хэрэглээгээрээ дэлхийд гуравдугаарт ордог. Хэлэлцээрт коксжих нүүрсний гаалийн татварыг тэглэснээр Монголын коксыг Японы зах зээлд нийлүүлэх боломж дээшилсэн. Түүнчлэн зэсийн хэрэглээ өндөртэй электроник, автомашины үйлдвэрлэл өндөр хөгжсөн Япон улс цэвэршүүлсэн зэсийг импортлох татвараа тэглэсэн нь Монголчуудад олдож буй дараагийн томоохон боломж билээ. Цэвэршүүлсэн зэс, кокс гэх мэт бүтээгдэхүүнийг аж үйлдвэр өндөр хөгжсөн Япон улсын зах зээлд худалдаалах тааламжтай нөхцөл бүрдэж байгаа нь Монгол улсын хувьд байгалийн нөөц баялагаа илүү үр өгөөжтэй ашиглах, ажлын байрыг нэмэгдүүлэх, тээврийн зардлыг хэмнэх боломжийг нээж өгч байна. Түүнчлэн хэлэлцээрээр хөрөнгө оруулалтын нөхцөл, боломжууд сайжирч байгаа тул Монгол улс зэс хайлуулах үйлдвэрлэлээ хөгжүүлэхдээ Япон улсын техник технологи, хөрөнгө оруулалтыг татах замаар энэ салбарт хамтран ажиллах боломж ч бүрдлээ.

Молибден, алт гэх мэт үнэтэй металл, түүхий нефтийг Японы зах зээлд нийлүүлэх шинэ боломжууд бий болсны зэрэгцээ эдгээр түүхий эдийг боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлд хамтарч ажиллах таатай хөрс суурь бүрэлдэн бий боллоо.

## Дүгнэлт

Монгол улс бол өрсөлдөх чадвар сул, жижиг эдийн засагтай, далайд гарах гарцгүй, эдийн засгийн хувьд хөрш 2 том гүрнээсээ ихээхэн хараат байдалтай улс юм. Эдийн засгийн хараат байдлаа бууруулахын тулд дэвшилтэт техник технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх замаар өрсөлдөх чадвараа дээшлүүлэх, үүний тулд орон зайн хувьд ойр дөт хөгжингүй улс орнуудтай эдийн засгийн гадаад харилцааны хүрээнд нягт хамтран ажиллах асуудал чухал байна.

Япон улстай байгуулсан ЭЗТХ-ийн гол зорилго нь богино хугацаанд хоёр орны хоорондох худалдааны хэмжээг нэмэгдүүлэх, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэхэд бус харин үйлдвэрлэлийн шинэ техник технологийг олж авах замаар өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, үйлдвэрлэлийн шинэ салбаруудыг хөгжүүлэх замаар “Голланд өвчин”-ий аюулыг тойрч гарахад чиглэж байгаа юм. Харин урт хугацаандаа Монгол улсын эдийн засгийг ирээдүйд авч явах шинэ залуу салбаруудыг хөгжүүлэх, улсын нийт экспортыг нэмэгдүүлэхэд чиглэж байна.

ЭЗТХ-ийг хэрэгжүүлэх явцдаа анхаарах чухал асуудал бол дунд болон урт хугацаанд олборлох үйлдвэрлэлийн салбарын үйлдвэрлэл огцом өсөх, экспортын орлого нэмэгдэх зэрэг өөрчлөлтүүдтэй холбоотойгоор үүсэж болзошгүй “Голланд өвчин”-ий аюул юм.

“Голланд өвчин” ба хямд импорт хоёрын аль аль нь ялангуяа уул уурхайн бус салбарын үйлдвэрлэл, ажил эрхлэлтэд муу нөлөөтэй. “Голланд өвчин” дотоодын үйлдвэрлэлийн зардлыг нэмэгдүүлэх нөлөөлөл үзүүлдэг бол ЭЗТХ-ийг байгуулснаар дотоодод зарим бараа, үйлчилгээний үнэ буурна. Үйлдвэрлэлийн зардал өсөх, үнийн бууралтыг дагалдан орлого буурах эдгээр үзэгдлүүд давхцсанаар үндэсний үйлдвэрлэгчдэд бизнес эрхлэхэд дарамт үүсч, зарим талаараа “Голланд өвчин”-д эрч нэмэх аюултай.

Хоёр орны худалдаа, эдийн засгийн харилцааны нөхцөл байдлыг судалж үзэхэд Монгол улс нь Япон улсын хувьд тийм ч ач холбогдолтой түнш биш юм. Учир нь манай улс Япон улсын гадаад худалдааны эргэлтэд маш бага хувийг эзэлдэг. Харин эсрэгээр Япон улс нь Монголын худалдаа эдийн засгийн томоохон түнш оронд тооцогдоно. Гэхдээ энэ нь хэлэлцээр Япон улсад огт хэрэгцээгүй зүйл биш бөгөөд ийм хэлэлцээр байгуулснаар газарзүйн байршлын хувьд хамгийн ойрхон бүс нутгаас хүнс, түүхий эдийн хэрэгцээгээ хангах боломж бүрдэж байгаа юм.

Монгол улсаас Японтой худалдааг өргөжүүлэхэд гарч буй гол бэрхшээл нь тээвэрлэлтийн өртөг зардлын асуудал юм. Монгол улсын хувьд харьцангуй

давуу тал бүхий ХАА, олборлох үйлдвэрлэлийн салбарыг тойрсон аж үйлдвэрийн кластеруудыг хөгжүүлэн, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, тээвэрлэлтийн өртөг зардлыг бууруулах боломжтой. Харин Японы талд түүхий эддээ ойрхон байршсан үйлдвэрлэлд хөрөнгө оруулалт хийж, үйлдвэрлэлээ өргөтгөх, өрсөлдөх чадвараа дээшлүүлэх боломж бас бий. Эдгээрийг хоёр тал хамтын хүчин чармайлтаар шийдвэрлэж, харилцан ашигтайгаар хамтран ажиллах өргөн боломж байна.

### **Ашигласан материал**

- Albertino Alesina, Enrico Spolaore and Romain Wacziarg “Trade, Growth and the size of countries” Handbook of Economic Growth, Volume 1B. 2005
- Armington, P. S. “A Theory of Demand For Products Distinguished By Place of Production.” International Monetary Fund Staff Papers 16: 159-178. 1969
- Arrow, K.J. and G. Debreu “Existence of an Equilibrium for a Competitive Economy” Econometrica 22, 265-90. 1954
- Arvind Panagariya “Preferential Trading Arrangements, Trade, and Growth” presentation at the joint World Bank-Central Bank of Chile Conference “The Future of Trade Liberalization in the Americas” on March 22 and 23, 2004 in Santiago, Chile.
- Bhattarai, K “Small Open Economy Model of UK” mimeo, University of Warwick, July.,1999
- Cheng, Kevin C., Growth and Recovery in Mongolia During Transition, IMF Working Paper WP/03/217, Washington D.C., November. 2003
- Dervis, K., J.De Melo, and S.Robinson “General Equilibrium Models for Development Policy”, CUP, New York. 1985
- Devarajan.S, Robinson.S “TMD discussion paper No 98” “The influence of CGE models on policy” August 2002
- Francisco Rodriguez and Dani Rodrik “Trade policy and economic growth: A sceptic’s guide to the gross-national evidence” Working paper series No.7081. National Bureau of Economic Research. Cambridge 1999
- Gylfason.T, Zoega.G., “Natural resources and economic growth” Central Bank of Chile. Working paper No 142., 2002
- Halit Yanikkaya “Trade openness and economic growth: a cross-country empirical investigation” Journal of Development Economics 72 (2003) 57– 89., October 2002
- Harry Bloch, Sam Hak Kan Tang “Deep determinants of economic growth: institutions, geography and openness to trade” 2006
- Mossa. Anisa Khatun and Hajime Inamura “A Dynamic International Trade Model

- Using Overlapping Generation and General Equilibrium Concept” 2002
- Nabil Annabi, John Cockburn and Bernard Decaluwé “Functional Forms and Parametrization of CGE Models” MPIA Working Paper 2006
- Osmani. S.R. “Towards an employment oriented pro-poor development strategy for Mongolia: A Background paper” UNDP Mongolia, 2006
- Pedro.A.M “Mainstreaming mineral wealth in growth and poverty reduction strategies” ECA policy paper No 1. 2004
- Reinert, K. A., and D. W. Roland-Holst. “Armington Elasticities for United States Manufacturing Sectors.” *Journal of Policy Modeling* 14, no. 5(1992): 631-639.1992
- Robison. S, Cattaneo. A “Updating and Estimating a Social Accounting Matrix Using Cross Entropy Methods” *Economic Systems Research*, Vol. 13, No. 1, 2001
- Roberta Piermartini and Robert The “Demystifying Modelling Methods for Trade Policy” WTO Discussion paper No 10
- Ross.M “How does mineral wealth affect the poor” 2003
- Rosser.A., “The Political Economy of the Resource Curse: A Literature Survey” IDS working paper 268. 2006
- Shantayanan Devarajan; Chalongsob Sussangkarn “Effective Rates of Protection when Domestic and Foreign Goods are Imperfect Substitutes: The Case of Thailand “ *The Review of Economics and Statistics*, Vol. 74, No. 4. (Nov., 1992), pp. 701-711.
- Shantayanan Devarajan, Sherman Robinson “TMD discussion paper No 98” “The influence of CGE models on policy” August 2002
- NSO of Mongolia., “Statistical yearbooks of Mongolia 1990-2015”
- Customs General Administration of Mongolia.”Foreign trade statistics of Mongolia 1995-2015”
- Bank of Mongolia 1995-2015. Annual Report . Mongol Bank .Ulaanbaatar. Mongolia
- UNDP (2002), Mongolia: Industrial and Trade Development Policy Review, Projec

## Хавсралт 1. Ерөнхий тэнцвэрийн загварын тэгшитгэлүүд

Барааны урсгал хөдөлгөөн	Үнийн тэгшитгэлүүд:	
$QX=AT[\eta^{oc}(PE)^{1+oc}+(1-\eta)^{oc}(PD)^{1+oc}]^{1/1+oc}$	$PX=1/AT[\eta^{oc}(PE)^{1+oc}+(1-\eta)^{oc}(PD)^{1+oc}]^{1/1+oc}$	
	$PE = (1 + te) * ER * PW_E$	
$QC=AC * [\beta * QM^v + (1-\beta) * QD^v]^{-1/v}$	$PC= 1/AC * [\beta^{om}(PW)^{1-} + (1-\beta)(PD)^{1-om}]^{1/1-om}$	
	$PM = (1 + tm) * ER * PW_M$	
$QX=AP_i[\omega_i * QVA_i^p + (1-\omega_i) * QINT^p]^{1/p}$	$PT = (1 + ts) * PC$	
$QVA_i = (\omega_i / (1-\omega_i))^{1/1+p} * (PINT_i / PVA_i)^{1/1+p}$	$PX_i = 1/AP_i[\eta^{oc}(PVA_i)^{1+oc} + (1-\eta)^{oc}(PINT_i)^{1+oc}]^{1/1+oc}$	
Нийгмийн тооцооны матриц дахь тэнцвэрийн нөхцлүүд		
QS	=	QD
$PD * QD + PE * QE$	$= PX * QX =$	$INT + W_L * L + W_K * K + tx * PX * QX$
$PC * (QH + QG + QI + QINT)$	$= PC * QC =$	$PD * QS + tm * PM * QM + PM * QM$
$W_L * L + W_K * K + FSAV + YG$	$= Y =$	$PC * (QH + QG) + SAV$
SAV	=	PT * QI
$td * PX * QX +$ $tm * ER * PW_m * QM -$ $te * ER * PW_e * QE + tc * PC * QC$ $+ tw * YH_i + tk * YH_k +$ FTRSFER	=	YG
SAV	=	PT * QI
$PW_m * QM$	=	$PW_e * QE + FSAV + FTRSFER$
YH	=	$QH * PT + SAV$
Загварын үндсэн тэгшитгэлүүд дэх товчилсон тэмдэглэгээ		
QX: Дотоодын үйлдвэрлэлийн нийлүүлэлт	PX: Дотоодын үйлдвэрлэлийн үнэ	
QC: Зах зээл дэх нийт нийлүүлэлт	PC: Дотоодын зах зээл дэх үнэ	
QVA: Нэмэгдсэн өртөг	PVA: нэгж барааны үнэ дэх нэмэгдсэн өртгийн жин	
QINT: Завсрын хэрэглээ	PINT: завсрын хэрэглээний өртөг	
QE: Экспортын бараа	PE: Экспортын барааны дотоодын үнэ PW <sub>E</sub> : Экспортын барааны дэлхийн зах зээлийн үнэ	
QM: Импортын бараа	PM: Импортын барааны дотоодын үнэ PW <sub>M</sub> : Импортын барааны дэлхийн зах зээлийн үнэ	
QS: Дотоодод үйлдвэрлэсэн барааны дотоодын зах зээл дэх нийлүүлэлт QD: Дотоодод үйлдвэрлэсэн барааны дотоодын зах зээл дэх эрэлт	PD: Дотоодын үйлдвэрийн барааны дотоодын зах зээл дэх үнэ	
QH: Өрхийн бараа үйлчилгээний нийт эрэлт QG: Засгийн газрын бараа үйлчилгээний нийт эрэлт QI: Хөрөнгө оруулалтын бараа үйлчилгээний нийт эрэлт	PT: Нийт бараа үйлчилгээний борлуулах үнэ	
$\sigma_e$ – Дотоодод үйлдвэрлэсэн барааны дотоодод хэрэглэх болон экспортлох хэсгүүдийн хоорондох орлох мэдрэмж	‘ td – Үйлдвэрлэлийн шууд татвар	
$\sigma_m$ – Импортыг орлох мэдрэмж	‘ tm – Импортын гаалийн татварын түвшин	
$\tau$ - CET функцын өргөжилтийн параметр	‘ te – Экспортын гаалийн татварын түвшин	

$\nu$ - CES функцын өргөжилтийн параметр	$\tau$ - Хэрэглээний татварын түвшин
$\eta$ - CET функц дахь экспортын хувь хэмжээний параметр	$\tau_w$ - Хүн амын орлогын албан татварын түвшин
$\beta$ - CES функц дахь импортын хувь хэмжээний параметр	$\tau_k$ - Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын түвшин
$W_k$ - Капиталын ахиу бүтээмж	SAV – хуримтлал
$W_l$ - Хөдөлмөрийн ахиу бүтээмж	FSAV – гадаадын зээллэг
K – капитал	FTRSFER – гадаадаас ЗГ-г шилжүүлсэн шилжүүлэг
L – хөдөлмөр	ER – валютын ханш
YH – өрхийн орлого	YG – төсвийн орлого

### Хавсралт №2. Ерөнхий тэнцвэрийн загварт ЧХХ-ийг тусгасан байдал

ЧХХ-ийн нөхцөл дэх барааны урсгал хөдөлгөөн	ЧХХ-ийн нөхцөл дэх үнэ
$QE_i = AE_i [\psi * QEP_i^{\tau} + (1-\psi) * QEO_i^{\tau}]^{1/\tau}$	$PX_i = 1/AT [\eta^{-\sigma_e} (PEO)^{1+\sigma_e} + (1-\eta)^{-\sigma_e} (PEP)^{1+\sigma_e}]^{1/1+\sigma_e}$
$QEP_i = AT_i^{-1-\sigma} \psi^{-\sigma} (PEP_i/PX_i)^{\sigma} QX_i$	
$QM_i = AM_i [\xi * QMP_i^{\tau} + (1-\xi) * QMO_i^{\tau}]^{1/\tau}$	$PM = 1/AC * [\xi^{\sigma_m} (PWO)^{1-\sigma_m} + (1-\xi)^{\sigma_m} (PWP)^{1-\sigma_m}]^{1/1-\sigma_m}$
$QMP_i = AT_i^{-1-\sigma} \psi^{-\sigma} (PC_i/PWP_i)^{\sigma} QM_i$	
QEP: ЧХХ-ийн түнш оронд гаргах экспорт	QEO: бусад улс орнуудад гаргах экспорт
QMP: ЧХХ-ийн түнш орноос авах импорт	QMO: бусад орноос авах импорт
PEP: түнш оронд гаргах барааны үнэ	PEO: бусад оронд гаргах барааны үнэ
PWP: түнш орноос авах барааны үнэ	PWO: бусад орноос авах барааны үнэ
$\psi, \xi, \tau$ - тэгшитгэлийн параметрууд	
$\sigma_e$ – түнш оронд гаргах барааны экспортын үнийн мэдрэмж	$\sigma_m$ – түнш орноос худалдан авах барааны импортын үнийн мэдрэмж